



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №06

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусн шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:

2021 оны 04 сарын 04-15 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус ОХУ, Украин, Герман, Өмнөд Африк, БНХАУ зэрэг улс орны шувууны аж ахуйд болон зэрлэг шувуудын дунд илэрсэн байна (Хүснэгт 1. Зураг 1. Шувууны томуугийн А хүрээний вирусн тархалт болон вирусн хэлбэр).

ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 04 сарын 04-15 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн 7 тохиолдол Нигери улсад шинээр бүртгэгдэв. 03 сарын 28 наас H5N1 вирусн өвчлөл Нигери улсын шувууны аж ахуйд (нийт 30) бүртгэгдсэн ба энд ажиллаж байсан 64 ажилчдаас шинжилгээ авахад 7 нь халдвар авсан нь батлагдсан байна.

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

Лаос улсад А хүрээний H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн 1 тохиолдол бүртгэгдээд байна. Энэхүү дэд хэвшинжээр үүсгэгдсэн хүний өвчлөл зөвхөн БНХАУ-д бүртгэгдэж байсан. Лаос улсын Луанг Прабанг мужид 5 настай хүү 2021 оны 03 сарын 28 наас өвчний шинж тэмдэг илэрч эмнэлэгт хандсан ба бүрэн эдгэсэн. 2014 оноос хойш H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөл 32 бүртгэгдээд байгаа ба үүнээс 8 өвчтөн нь нас барсан.

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 04 сарын 04-15 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H7N9 вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 04 сарын 04-15 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H9N2 вирусн хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 04 сарын 04-15 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 04 сарын 04-15 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.


ДОЛОО. 2021 оны 04 сарын 04-15 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн хүний болон шувууны мэдээлэл:

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирус тархалт болон вирус хэлбэр

№	Мэдээлсэн өдөр	Шувууд өвчилж эхэлсэн өдөр	Дэд хэвшинж	Улс	Муж	Өртсөн нийт шувуудын тоо	Хүн болон өртсөн шувуудын зүйл
1	28/3/2021	30/3/2021	H5N1	Нигер	Кано, Плато	7	Шувууны худалдаачин, фермерийн ажилчид
2	28/3/2021	9/4/2021	H5N6	Лаос	Луанг Прабанг	1	5 настай хүүхэд
3	7/4/2021	25-03-2021	H5N5	Орос	Бахтемир	2	Laridae-Цахлайнхан Pelecanidae-Хотонгийнхон
4	5/4/2021	4/2/2021	H5	Украин	Балабанаски	4	Red-footed falcon
5	5/4/2021	3/1/2021	H5N8	Герман	Берлин	10	Тахиа
6	11/4/2021	9/4/2021	H5	Өмнөд Африк	Гаутенг	29000	Тахиа
7	13/4/2021	12/4/2021	H5N6	БНХАУ	Ляонин	291	Усны шувууд

Эх сурвалж: www.poultrymed.com, Cidrap.umn.edu

(Зураг 1) Шувууны томуугийн А хүрээний вирус тархалт /зургаар/



ДОЛОО. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдолын мэдээлэл:

2021 оны 04 сарын 04-15 ны хооронд шувууны томуугийн өвчлөлийн сэжигтэй, үхсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Шувууны томуу хариуцсан баг